



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/241

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/145 дугаар тушаалын дагуу 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 7 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд Баянжаргалан, Өндөршил сумдын үхэр болон бог малыг гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов хүргэж, зарлан мэдээлэлж ажиллахыг тухайн сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210030

Аймгийн Засаг даргын 2021 оны
06 дугаар сарын 23-ны өдрийн
А/гч дүгээр захирамжийн хавсралт

ШҮЛХИЙН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Шүлхийн дархлаажуулалтанд хамрагдах малын тоо				Тун
		Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	
1	Баянжаргалан	4,256	85,000	85,000	174,256	89,256
2	Өндөршил	4,400	38,200	38,200	80,800	42,600
	ДҮН	8,656	123,200	123,200	255,056	132,000